



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/641

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт махны үйлдвэрлэл эрхэлж буй бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, Монгол улсын Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг хангуулах, үйлдвэрлэлээс гарсан бохир ус зайлуулах технологи үйл ажиллагаанд гарсан хүндрэлтэй нөхцөл байдлыг судлан дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Гансүх (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Я.Эрхэмбаяр

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Л.Ариунаа

(Мал эмнэлгийн газрын дарга)

П.Мөнхжаргал

(Байгаль орчны газрын дарга)

Ч.Батсүх

("Хөвсгөл ус суваг" ХХК-ийн захирлын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Батдорж

(Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)

П.Эрдэнэсайхан

(Хүнсний үйлдвэрлэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Н.Дамбадаржаа

(Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын
улсын байцаагч)

А.Цэнд-Аюуш

(Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын
байцаагч)

Нарийн бичгийн дарга:

Б.Ганзориг

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын дарга)

2.Ажлын хэсгийг хуралдуулж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангуулах санал, зөвлөмж, дүгнэлт гарган аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012075